

БАТЛАВ
БОЛОВСРОЛЫН САЙД П.НАРАНБЯЯР



МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарчмаар сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах, "Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээг оновчтой хэрэгжүүлж, сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлж, салбар дундын дадлагын бааз байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгыг 2024-2025 оны хичээлийн жилд дэвшүүлж байна.

Энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх хүрээнд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон батлагдсан дүрэм, журмыг олон нийтэд сурталчлан таниулах;
2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалга шаардлага, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн индексийг нэвтрүүлэх, сургалтын хөтөлбөрийн чадамжийн санг бүрдүүлж, сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
3. Пийрсон (Pearson VTEC) мэдээлэл технологи, англи хэлний сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээг өргөжүүлэх;
4. Төрөлжсөн ахлах сургуульд хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг холбогдох байгууллага болон мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай хамтран туршилтаар хэрэгжүүлэх;;
5. Хосмог сургалт, ажлын байран дахь сургалтад ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагын захиалгын дагуу иргэд, суралцагчийг хамруулж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;
6. Цэрэг, цагдаа, онцгой байдлын салбарын алба хаагчдыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаар дамжуулан мэргэжлийн сургалтад хамруулан, мэргэжил, ур чадвар олгох;
7. Суралцагч бүр сургалтын байгууллагын орчинд амар тайван суралцах, хүний эрхийг дээдэлсэн тэгш, хүртээмжтэй, эрүүл аюулгүй, суралцах жендерийн мэдрэмжтэй нөхцөлийг бүрдүүлж, үр дүнг тооцох;

8. Багш шинээр бэлтгэх, давтан сургах, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, салбар бүрийн шилдэг мэргэжилтнийг багшаар бэлтгэх замаар мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хомсдолыг бууруулах;

9. Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитоор үнэлэх, багшийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, багшийн бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх;

10. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, салбар дундын дадлагын баазыг байгуулж хөгжүүлэх;

11. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх.

...оОо...